

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лутын Норов	Дугаар	L248
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Номгон сум
Төрсөн газар	Номгон сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Сангийн далай хийд	Сүм хийдийн дугаар	ӨГНМ 029
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-рсарын 12	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Номгон сумын Сангийн далай хийд

Гантулга: За судалгааны багийнхан 2007 оны 6 сарын 12-нд Өмнөговь аймгийн Номгон сумын төв дээр ирээд Сангийн далай хийд дээр шавилан сууж байсан Лутын Норов гэж өндөр настантай Сангийн далай хийдийн талаар ярилцах гэж байна. За та өөрийгөө таницуулна уу?

Норов: Энэ нутгийн Лутын Норов гэдэг хүн л байна даа. Тэгээд Сангийн далай хийдэд шавилан сууж байсан. Шавилан сууж байгаа тэгээд хийд хураагдах үед л ...

Гантулга: Хар болсон?

Норов: Ламын цаазанд ч ороогүй, хар хүн гээд цэрэгт явж байсан. Цэрэгт явж ирээд тэгээд бараг л мал малласан, нэг насаараа малчин хийж явсан даа. Нэг л нэгдэл анх эхлэхэд нь одоо энэ хүрээн дотор байгаа нэг сүмд бид нарын хориод хүн цуглаж нэгдэл байгуулах уу яах уу гэж тэгээд анх ардын хурал гэж эхлээд сүүлд нь одоо...найман настайдаа суусан байна уу...

Гантулга: Тэгээд хэд хүртлээ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов:Тэгэхээр цэрэгт...цэрэгт чинь би...Өө наймаас дээш , энэ арав орчимтой суусан байж таарах гэж байна.Тэгээд хийд хураагдах үед, би чинь 39 онд цэрэгт явж байгаа гэдэг чинь хийд хураагадаад нэг хоёр жил болсон.

Гантулга: Тэгэхэд та хэдэн настай байсан.

Норов:Тэгэхэд нэг арван тав, зургаатай л байсан байх.Тийм л үе байж таарах гээд байна.

Гантулга: Аан за, энэ одоо Сангийн далай хийдийг юу гэж нэрлэдэг байсан юм бэ, энэ Гандантэгчилэн гэдэг шиг тусгай нэр байсан уу?

Норов: Үгүй ээ ер нь, зөв ярьж байна уу, буруу ярьж байна уу.Үүдэн дээр нь нэг дээр нэг, санаанд байдаг юм.Дашин Чойнхор Дамбадаржаалин гэж л бичиг байсан.

Гантулга: Өмнөөгөөр өөр нэрлэдэг байсан уу? Дацан тус бүрдээ ч гэдэг юм уу?

Норов: Тийм нэртэй, цогчин сүмийн үүдэнд тийм нэр л байдаг байсан шиг санаж байна. Дацангууд бол тус тусдаа нэртэй, адресстай л байсан байж таарна.

Гантулга: Аа тэрийг бол мэдэхгүй?

Норов:Тийм.

Гантулга: Энэ Сангийн далай, хэзээ ямар хүн байгуулсан хийд вэ?

Норов:Тэрнийг бол ерөөсөө мэдэхгүй.Чухам хэдэн жил болсон юм.

Гантулга: Хуучин аль засгийн аль хошуу харъяаны хийд байсан юм?

Норов: Одоо л энэ Түшээ гүн гэж ярьдаг, тэр юм болов уу.

Гантулга: Сайн Ноёны юу?

Норов: Тийм.

Гантулга: Сүм хийдийн ойролцоох газрын нэр усыг нэрлэвэл?Одоо ингээд энэ ойр орчим байгаа?

Норов: Одоо энэ өмнөө нэг задгайтай.Бүр түүхээр яривал нэг ганц лам явж байгаад, нэг тийм жоохон шалбааг юу байсан юм бэ дээ, тэгээд тэр нэг сан тавиад гарсан задгай ус одоо Рашаан ус л гэж ярьдаг юм, бид нар.Энэ өмнө задгай байгаа.Тэгээд одоо Сангийн далай чинь одоо ямар сан, ямар далай тэгээд л эхэлсэн нэр юм гэж үг байдаг юм.

Гантулга: Аан за тийм, түүхтэй?

Норов: Тийм юм гэнэ лээ. Тэгээд энэ дээр хийд байгуулсан, тийм л учиртай юм гэнэ лээ.Чухам аль оныг мэдэхгүй юм.

Гантулга: Тэр хошуу ноёны нэрийг бол та мэдэж байна уу? Энэ хийд байгаа газрын харъяаны нийт хошуу нутгийн засаг ноёны нэрийг та мэдэх үү?

Норов: Мэдэхгүй ээ, намайг байх үед энүүхэн харъяалж байсан Мээрэн гэж байсан юм уу.Ядам Мээрэн гэж байсан юм уу, Мээрэн л гэж нэг хүн.

Гантулга: Урдаа бол задгай устай юм байна, тийм ээ?

Норов: Тийм. Урдаа задгай устай.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ойр хавьд тойроод ингээд хэлвэл, уул ус?

Норов:Өө тэр задгай устай, тэгээд энэ баруун хойноо хоёр жаахан овоо, Морьт овоо, Дун овоо.Тэгээд энэ баруунтаа тахидаг Хайрхан овоо нь энэ Мандал хайрхан гэж овоо байгаа.Тэрийг чинь бас сая нэг хүн ирж, хэдэн улс нэг өдөр тахисан.Ийм учиртай юм, тэр Мандал хайрхан ерөөсөө, Сангийн далай хийдийн гол тахидаг хайрхан нь тэр Мандал хайрхан, тэгээд Дун овоо. Эднуудын дунд л явдаг байсан.

Гантулга: Өөр энэ тэр Сангийн далай гэж нэрлээд байгаа тэр ус бол тахилгатай байсан уу,зүгээр?

Норов: Усны тахилгыг мэдэхгүй.Ер нь энэ цам гарахад тэр цамын нэрээр задгайн эзэн яах аргагүй цагаан царайтай, тийм ээмэгтэй хүн. Тэр ээмэгтэй байдаг байсан. Дун цагаан царайтай тийм ээмэгтэй цам гардаг байсан.Тэр Морьтхайрхны эзэн гэж бас цам байдаг шиг санаж байна.Тэр Мандал хайрхны эзэн чинь эрэгтэй хүний дүрстэй, цөс үхрийн царайтай, ардаа их олон дуулгатай тийм том шүтээн цам байдаг байсан.Тийм л юм байгаа юм.Тэгээд жилд л очиж овоогоо тахихдаа эндээс шүтээнээ моринд ачаад лам нар ингээд явчихна. Тэгээд л наад энгэрт нь буучихаад л дунд нь нэг хөтөл байгаа, тэрэн дээр нь тэр майхнаа шаачихаад л тэгээд л идээ будаа юу байна.Тэгэхдээ ер нь тэр үед яг ээмэгтэй хүн ер нь хайрхан дээр гарч байсан удаа байхгүй юм.Дандаа лам нар л гарч байсан байгаа юм.Ийм л байгаа юм.Тэгээд тэр Мандал хайрхныг тахичихаад энэ Дун овоогийн баруухан хойд тал дээр ирээд наадмаа хийдэг.Тийм наадмаа хийдэг талбай байгаа юм.

Гантулга: Аа мөн мөн.

Норов: Бас морь давхидаг, хэдэн бөх барилддаг тийм л байсан.

Гантулга: Ойр орчимд одоо энэ урагшаагаа Эхэн загийн хийд, тэгээд цаашаагаа энэ юу энэ тэр гээд ойрхон хийдүүдийг нэрлэвэл?

Норов: Улаан эрэг гэж...

Гантулга: Улаан эрэг бий?

Норов: Тийм.

Гантулга: Эхэн заг?

Норов: Өөрөөр мэдэхгүй.

Гантулга: Өшөө бол мэдэхгүй юу?

Норов: Өшөө бол мэдэхгүй.Тэгээд цаашаа хил болоод явчихдаг юм.

Гантулга: Энэ Сангийн далай хийд чинь Уртын хийдтэй ямар холбоотой юм бэ? Сангийн далайтай харъяатай байсан байна уу, зүгээр хамаагүй юу?

Норов: Тэр холбоог нь болвол би мэдэхгүй юм.Уртын хийд гэж байсан байгаа юм.

Гантулга: Хойшоогоо бол холбоо байхгүй юу, өөр хийдүүд рүү?

Норов: Үгүй ээ, энэ Балгасан гол гээд л нэг хийд байсан.

Гантулга: Аа тэндээс лам нар?

Норов: Тэндээс лам нар их хүрж байсан , тийм удаатай.Тэндээс чинь одоо мундаг лам нар , маарамба дооромбо нэртэй хоёр лам, тэгээд бас бус олоул.Тэгээд л дандаа мориор, тэр үед ч одоо ямар машин,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

мотоцикл байх вэ дээ.Морьтой лам нар л ирж энэ хойд тал дээр хүлээж авж байхыг би бас хүүхэд харж тосж байсан.Бүрээ, бишгүүр болчихсон, наанаас чинь энэ одоо очоод л цагаан хүрээ чинь байсан, цагаан хүрээний өмнө талдаа тэр асар гэж том юм байсан.Тэрэн доороо бүрээ бишгүүрээ үлээгээд л тэгээд тойроод , ингэж тойроод тэгээо л хүлээж авдаг.Тэгээд л явганаар яваад л ,тэгээд түүгээр л орж байсан санагддаг юм.Маарамба, дооромбо гээд л хоёр лам...

Гантулга: Хийд хаагдахаас өмнө, хийдийн зургийг зурсан байдаг болов уу, энэ дацан юм уу, цогчин дуган дотроо зурсан , одоо тийм дуган тийм дацан гээд нийтэд нь, нийтээр нь?

Норов: Тэрийг бол мэдхгүй юм.

Гантулга: Шарын шашны хийд байсан уу?

Норов: Одоо шарын шашин л гэдэг байсан байх.

Гантулга: Одоо дацангууд нь , цогчин дуган тус бүрдээ шүтээн , ядам, сахиустай байсан уу?

Норов: Тийм байсан байлгүй дээ.

Гантулга: Тэд нараас нь нэрлэвэл, цогчин дуган нь ямар сахиустай байсан юм?

Норов: Одоо бодоход бол нэг том том Богд ламын л малгай байдаг байх даа.Шовгор оройтой малгай өмсчихсөн том том бурхнууд л байдаг байсан.Аа тэр хангалууд бол тусгай, цогчин сүмээсээ тусгай тэр баруун талд нь нэг жижиг сүмд арван хангал.Тэгээд арван хангал гэхлээр чинь янз бүрийн...

Гантулга: Жигжид?

Норов: Догшин бурхнууд байдаг байж дээ. Саадаг нум үүрсэн, морь унасан бурхан ч , Чоймбол бурхан ч байдаг байсан,Янз бүрийн бурхан.Тэгээд тус тусдаа хурдаг байсан.Тэр цогчин сүмүүдийг хурдаг тэр цогчиноороо хөгшин залуу ном мэддэг мэддэггүй хурна гэж байхгүй.Дандаа тийм хуралд бол тэр ном мэддэг улсуудаа хурдаг байсан байх.

Гантулга: Та бол цогчин, дуганых уу, дацангийн хүн байсан уу?

Норов: Өө би чинь цогчингийнх, цогчингийнх л байсан.

Гантулга: Цогчин дугандаа ер нь хичнээн лам хурдаг байсан бэ? Тогтмол?

Норв: Мэдэхгүй ээ, олон л жаа, жавдан байдаг байсан.Нэг жаанд хэдэн лам нар байдаг байсан юм.Гэхдээ одоо энэ байгаа сүмүүдтэй адилгүй том сүм байдаг байсан юм.

Гантулга: Энэ лам нар нь энэ хошуу нутгийн улс байх уу, өөр хошуу нутгаас бас энд ирж шавилан суудаг байсан уу?

Норв: Тэр цагийн хуралд бол энэ тэндээс лам нар уригддаг юм уу, өөрсдөө ирдэг юм уу. Мэдэхгүй. Ирдэг л байсан.Эхэн загаас лам нар ирнэ, энэ хавийн хурал хийдээс тэр чойрын хуралд ирж оролцдог байсан байх.Нэг их олон лам нар ирээд л тэр лянх мордоно гэж...

Гантулга: Аа лянх дом?

Норов: Тийм, олон цагаан морьтой улс л ирээд энэ гороо тойроод энэ зүүн шар хад гэж байдаг юм.Тэрэн дээр очиж наадам хийж байсан санагддаг юм.Тэгээд л лам нар очоод л , тэгж байсан нь санаанд байдаг юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Сангийн далай хийдийн хувилгаан нь , эзэн нь орон хийдийн эзэн лам нь?

Норов: Билэгт хувилгаан гэж хүн байсан юм.

Гантулга: Тэр хүний тухай жаахан тодруулаач?

Норов: Тэгээд энэ лам нар нь ярихаар бол Өршөө л гэдг юм.Өршөө лам л гээд.Тарган цагаан лам л байсан, миний мэдэх.

Гантулга: Хурал хаагдахад байсан уу, өмнө нь үгүй болсон уу?

Норов: Өө өмнө нь үгүй болсон.Хурал хаагдахаас өмнө үгүй болсон.

Гантулга: Өөр одоо том эрдэмтэй лам нар, одоо аграмба ч гэдэг юм уу?

Норов: Гомбо аграмба гэж. Хамгийн том лам нь юм.

Гантулга:Сүүлдээ?

Норов: Тийм.

Гантулга: Их эрдэмтэй лам уу?

Норов: Тэр эрдэмтэй , номтой лам байсан байх.

Гантулга: Өөр дооромбо, зийрэмбэ, маарамба гэвэл?

Норов: Аа дооромбо гэж дуулаагүй, маарамба л гэж ганц лам байсан. Аа харин Балгасан голоос, маарамба, дооромбо гэж хоёр том лам олон шавь нараа, олон морьтой ирдэг байсан.Тэрнийг хүлээж авч, хүндэлж тэгж байдаг байсан юм. Чойр, урьд нь чойр тэгж нэг их барьж, яадаг байсан юм уу үгүй юм уу.Дом дамжаа гээд л , нэг хэдэн улс хоёр жил л барьсан уу, гурван жил барьсан.Тэгээд л хийж байгаа харагдсан.

Гантулга: Тэр Билэгт хувилгааны өмнө дүрүүдийн талаар бол та дуулсан уу?

Норов: Тэрийг бол мэдэхгүй.

Гантулга: Төвдөөс ер нь том том аграмба, маарамба, гавж нар ирж багшилж байсан уу?

Норов: Тэрнийг бол би мэдэхгүй юм.Зүгээр Төвдөөсөө яагаад л цаанаасаа тангад л гэдэг юм. Их урт юутай, зүгээр хааяа л нэг тийм улс ирдэг байсан юм. Тэрнийг л буулгачихна, газар хүрэхээр.Тийм юм байдаг юм уу, номын чадал эрдэм нь байдаг юм уу.

Гантулга: Гэлэн сахилтай улсууд олон байсан байх даа?

Норов: Ээ байсан, байдаг байсан байх.

Гантулга: Нэртэй зурхайч, эмч нар гэж дуулсан уу та? Зураач, одоо бурхан бүтээгч, бурханч лам?

Норов: Зурхайч нар бол харин гайгүй хэдэн зурхайч байдаг байсан юм.

Гантулга: Жишээлбэл?

Норов: Хамгийн эхний зурхайч тэр Хамир зурхайч гэж байдаг байсан юм.

Гантулга: Хамир зурхайч?

Норов: Тийм, Хамир зурхайч гэж байдаг байсан. Түүний шавь нар нь за тэгээд л Чимэд зурхайч, за тэгээд л Наваанлувсан.Тэгээд жижиг зурхайч нар байсан л байх.Тийм улсууд байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Цогчин дуганы хамба лам, гэсгүй , унзад ,цорж, даа лам даамал няравуудыг та одоо нэрлэвэл чадах болов уу?

Норов: Чадахгүй байх аа.Цогчин унзад гэж Чинзээ гэж нэг хүн байдаг байсан юм.

Гантулга: Чинзээ гэж?

Норов: Тийм, бүдүүн дуутай.Тусгай, зааны ард тусгай нэг суудалтай.Тэгээд л бас нэг нэлээн эрхтэй, дархтай тийм л хүн байсан.

Гантулга: Гэсгүй нь ямар хүн байсан юм?

Норов: Аа гэсгүй ч одоо Наваан гэсгүй гээд л байсан.Өөр чинь юу билээ дээ. Наваан гэсгүй л гэж магад байсан.Дамбий даа лам гэж бас байсан.Гэсгүй нь нэг л байдаг байсан ...

Гантулга: Нэг л байдаг байсан , аан за?

Норов: Биег гээд л нэг жижиг гэр бариад суучихсан...

Гантулга: Туслах нь ?

Норов: Тийм, туслах нь байдаг байсан.Одоо яривал цагдаа юм уу, юу юм.Туслах нь одоо Чаврий гэж хүн байгаа.

Гантулга: Сангийн далай хийд чинь одоо хичнээн дацантай, хичнээн суваргатай, хичнээн сүмтэй хийд байсан бэ? Тус бүрээр нь нэрлэвэл?

Норов: За би нэрийг нь хэлчихэж чадахгүй ээ .Энэ лам нар ингээд л хийдийгээ гороолоод л явдаг.Тэгээд ер нь энэ хийдийн хойд талд байдаг , найм гэдэг билүү хэд билээ олон цагаан суварга байдаг байсан.Тэгээд л гороо эргэж яваад л , нөгөө хэдэн суваргыг чинь дор дороо эргээд л ...

Гантулга: Гороо эргээд л ?

Норов: Тийм, тэгээд л замаар явж байгаад л хүрд гэж байгаа юм.Маанийн хүрд, том жижиг , өвгөн хүрд ч гэж байх шиг, тийм хүрднүүд байдаг.Тэгээд л өнөө гороогоо эргээд л , маанийнхаа хүрдүүдийг эргүүлээд л , тэр суваргануудаа эргээд л тэгээд л одоо уншлага муншлага гэж юу хийдэг юм мэдэхгүй.Тэр хийдийн том лам нар одоо тэгээд л гороолоод л суучихсан, орой ч юмуу, өглөө орой явцгааж байдаг.Тийм л байсан.

Гантулга: Тэр дацангуудыг нэрлэвэл? Жишээлбэл цогчин гээд?

Норов: Тэр цогчин сүм, цогчин сүмийн хоёр талд нь хоёр жижиг сүм, баруун талд нь арван хангал байдаг, хурдаг.Тусгай хурдаг, тийм сүм байсан.Тэгээд бодвол, том ном мэддэг улсууд зүүн талд нь майдар гээд ганц том сүм байдаг байсан.Тэр майдар гээд зүүн өмнө нь Гүнрэг сүм гэж байгаа юм .

Гантулга: Аа гүнрэг?

Норов: Тэгээд гүнрэгийн сүм гэдэг ичнь дандаа тийм ...

Гантулга: Гүнрэг хийд, чагжаа хийд?

Норов: Дандаа чагжаа хийдэг, тийм сүм байсан шиг санаж байна.

Гантулга: Тэгээд?

Норов: Тэгээд тэр баруун өмнө нь байгаа одоо тэр томоохон харагдаад байгаа сүм, тэр яг хайлан хийдэг сүм.

Гантулга: Хайлан хийдэг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов: Дөчин тав хоногийн хайлан хийгээд тэгээд нөгөө ханцугүй...

Гантулга: Ламын хувцас?

Норов: Энгэр ташуу хувцас, түүнийг өмсчихөөд хураад л тэгээд дөчин тав хоног хурлаа хийчихнэ.Тэгээд л хөдөө хайлангийн найр хийнэ...

Гантулга: Жанжуу, хайлангийн жанжуу?

Норов: Жанжуу, тийм сайн мэдэхгүй/ инээв/ Дагаад л шогшиж байсан, лам багш нарыг дагаад л ...Олонхон адуутай, ихээхэн айрагтай бол хонуут өнжүүт явна. Багахан айрагтай, юу хайлангийн мэдээ гээд адуу уясан барьсан улсууд , одоо мэдэгдсэн байдаг юм уу, яадаг юм .Тэгээд л айлуудыг хэсээд л , дамжаад л энүүгээр тэрүүгээр ороод л явдаг байсан юм.

Гантулга: Дацангуудаас нэрлэвэл? Ямар ямар дацан байсан?

Норов: Тэгээд энэ одоо энэ хойно нэг хоёр сүм байна.

Гантулга: Аа энэ хашаан дотор?

Норов: Тийм, тэр хоёр сүм чинь нэг нь дүйнхор.

Гантулга: Дүйнхор дацан?

Норов: Тийм, нэг нь жүд.

Гантулга:Жүд дацан?

Норов: Тийм дацан байсан.Жүд дацан байсан.

Гантулга: Энэ тэгээд хашаан дотор өөр дацангууд байсан уу, дацан сүм?

Норов: За өөр мэдэхгүй ээ. Зүүн хойд өнцөгт бол Улаан ядам, улаан сахиус.

Гантулга: Жамсран?

Норов: Жамсран. Тэр бол энэ хийдийн хамгийн гол чухал...

Гантулга: Сахиус?

Норов: Шүтээн.Өдөр шөнөгүй салхи тавина гээд л нэг ном сайн мэддэг хүн шөнө ч очоод л цан хэнгэргээ л дуугарч байдаг.

Гантулга: Уншиж байдаг?

Норов: Тийм, уншиж байдаг.Тийм байсан , тийм л юм гэнэ лээ.

Гантулга: Та бас энэ гадуур нь бас хоёр гурван сүм байсан, байхгүй болсон гээд байсан, түрүүн?

Норов: Аа тэр голд нь байгаа том цогчин сүм алга.

Гантулга: Алга байна?

Норов: Хоёр талд нь байсан хоёр жижиг сүм байхгүй.

Гантулга: Тэр нь юу юуны сүм байсан юм?

Норов: Энэ баруун талд нь өнөө арван хангал, Гомбын сүм л гэж байсан юм.Гомбо л юм тэр чинь ерөөсөө.Гомбо гэдэг чинь одоо бас нэг...

Гантулга: Арван хангалын нэг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов: Арван хангалын л нэг. Зүүн талд нь өнөө майдар бурхан. Тэр ч бас ямар хурал хурдаг юм, би бас сайн мэдэхгүй л байна шүү. Тэр үеийг бол заримыг нь мэднэ, зарим том том юмыг нь... Үгүй ээ энэ цогчин сүмд л хийж байсан.

Гантулга: Аан за?

Норов: Цогчин сүмд л хийж байсан шиг санаж байна.

Гантулга: Чойр дацан гэж байсан болов уу?

Норов: Чойр дацан гэж бол байгаагүй байх аа. Ер нь тэгээд л чойр дацан бол эхлээд буй болох гэж, өнөө дамжаа барихад чинь хүн болгон нэг хурал номыг дааж, хүлээж авдаг хүнүүд байдаг шүү дээ.

Гантулга: Домын дамжаа барихад уу?

Норов: Домын дамжаа барихад, тийм.

Гантулга: Хувааж авдаг?

Норов: Тийм, хувааж авдаг.

Гантулга: Аан хурлаа хувааж авдаг?

Норов: Тийм.

Гантулга: Суваргууд нь бол бодь суварга л байх уу, өөр янзын суварганууд байх уу?

Норов: Чухам бүү мэд, нэг сайхан цагаан суварганууд л байдаг байсан, том том...

Гантулга: Ном барладаг байсан уу, Сангийн далайд?

Норов: Барладаг байсан.

Гантулга: Модон бар?

Норов: Тэр модон барыг чинь хийдэг хүн ч байхыг би нүдээрээ харж л...

Гантулга: Ганжуур данжуур?

Норов: Аа байсан байсан. Тэр цогчин сүмийн чинь баруун хойд, зүүн хойд өнцөгт, ганжуур данжуур гэдэг чинь тэнд байдаг байсан юм. Тэр ганжуур, данжуурыг чинь одоо гороолно гээд тэр хөдөөний улсууд чинь тэр хааяа хааяа...

Гантулга: Залж аваад л эргэдэг?

Норов: Залж авдаг, тэр хүнд одоо бас тэгэх шаардлага байдаг юм уу яадаг юм. Тэгээд л ганжуур гороолно гээд хэд эргэдэг юм бүү мэд. Өнөө ганжуурыг чинь сольж үүрээд л өдөрт яваад байна. Тэр цогчин сүмэнд сууж байгаа нэг сахилгагүй том өвгөн нэг муу бандийг харж л байлгүй дээ.

Гантулга: Цам гардаг байсан уу?

Норов: Аан?

Гантулга: Цам гардаг байсан уу?

Норов: Лхам бурхан уу?

Гантулга: Цам, цам бүжиг?

Норов: Өө гаралгүй яахав.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Майдар эргэдэг байсан уу?

Норов: Эргэдэг байсан.Майдрын ногоон морь гэж байдаг байсан, тусгай тэрэгтэй.

Гантулга: Хэдий үед эргэдэг байсан?

Норов: Аан зун намар л юм даг.Энэ овоо тахилгаас хойно хийдэг байл уу, мэдэхгүй.

Гантулга: Сор залдаг байсан уу?

Норов:Сор залдаг байсан.Энэ баруун тийш нь аваачаад л ...

Гантулга: Цам нь олон багтай байсан уу?

Норов: Байсан. Зуу гаруй цамтай байсан байх.Эхлээд л хамгаас урдаар нөгөө тодгом, хохимой ч билүү, юу билээ.Хоёр цагаан юм гараад л цамнаж байсан, сүүлд нь азар гээд л нэг могой байсан, хоёр ширхэг зангилаа хамартай.Одоо цагдаа юм уу даа, юу юм.

Гантулга: Тийм дэгээр гарна энэ тэр гээд л , хүрээ дэг ч байдаг юм уу?

Норов: Байдаг байлгүй.Тэр чинь тусгай багштай...

Гантулга: Аль дацангаасаа гардаг байсан, цогчин дуганаасаа гарах уу?

Норов: Цогчиноос л гарна.

Гантулга: Майдрын цам гардаг байсан уу?

Норов: Цогчин дуган гэдэг нь үүдэндээ одоо юу гэх юм бэ дээ, саравч пүүсгэдэг юм уу. Тэр дотор чинь олон хүн..

Гантулга: Их том заал?

Норов: Тийм тэр дотор л орно.Бүх цам л гардаг байсан байх.

Гантулга: Майдар эргэхэд майдрын цам гэж гарах уу?

Норов: Майдрын цам гэж гарсныг би мэдэхгүй юм.Зүгээр яахав хойгуур энэ нэг, дүйнхор ...Дүйнхор гэдэг чинь нэг ямар цам нь билээ.

Гантулга: Цагар чогор гэж нэг?

Норов: Ээ тийм.

Гантулга: Цагар чогор?

Норов: Хэдэн том оо лам нар бас нэг ийм цам...

Гантулга: Дүйнхор дацангаасаа эримээ уншаад?

Норов: Тийм, эрим уншчихсан.

Гантулга:Чогор гэж?

Норов: Одоо энэ бүжиг, жүжиг ч юм уу, тэгээд л амаараа одоо уншдаг хэлдэг юу байдаг юм.Тэгээд л чодгор гэж гардаг байсан шиг санагдах юм.

Гантулга: Чодгор оо, чогор?

Норв: Чогор юм уу...

Гантулга: Цагар чогор ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов: Тийм.

Гантулга: Цогчин дуганы уншлагыг нэрлэвэл? Тийм тийм ном уншдаг байсан гэж?

Норов: За ер нь , эхлээд тэр лам нарууд тэр цогчин сүмийнхээ өмнө тал бүрээсээ цуглаад цөмөөрөө нэг жанч, манч нөмөрсөн нь нөмрөөд үгүй нь нөмрөөгүй л байсан байх даа.

Гантулга: Тал бүрээсээ цуглаад л ?

Норов:Тийм, цуглаад л өнөө мэгзэм уншаад, тэр чинь аятай, дантай...

Гантулга: Дуганыхаа урд?

Норов: Өө тийм, дуганыхаа өмнө жигтэйхэн юм болно.

Гантулга: Та унш даа, жоохныг?

Норов: Өө би бас тогшиж л байсан болохоор...

Гантулга: Одоо жоохныг уншаад өг дөө?

Норов: За энэ чинь/инээв/

Гантулга: Аялгуутай, яг хуучин уншдагаараа?

Норов: Аа мэдэхгүй.Сүрхий л аятай дантай уншиж байсан.

Гантулга: Одоо мартсан уу?

Норов: Өө мартчихжээ.

Гантулга: Таныг байхад энэ хурал тараагүй байхад нэмж ер нь сүм дуган баригдсан уу, хийд дээр ер нь?

Норов: Үгүй ээ мэдэхгүй юм.

Гантулга: Шинээр эхэлж барьсан?

Норов: Эхэлж байж байсан юм байхгүй байх.

Гантулга: Цогчин дуган дотор та нэг том бурхан байсан гэсэн, ямар бурхан байсан гэлээ?

Норов: Өө бодвол тэр чинь одоо...

Гантулга: Суугаа майдар гэлүү?

Норов: Гомбо, майдар ямар ямар ч байсан юм...

Гантулга: Та нэг суугаа бурхан, том бурхан?

Норов: Суугаа шуумал бурхан. Шовгор оройтой.

Гантулга: Баншуй малгай?

Норов: Аан ?

Гантулга: Баншуй малгай?

Норов: Тийм, баншуй малгай.За н.эг тиймэрхүү л бурхнууд байсан байх даа.

Гантулга: Ганжуур эргэдэг байсан, хошуу эсвэл хүрээ хийдээ гороолдог байсан уу, ганжуураараа? Зүгээр мөргөлчид яадаг байсан юм уу?

Норов: Мөргөлчид л нэг нэгээр нь юм уу, зарим нь давхарладаг юм уу, дан дангаар нь юм уу, тэр чадлаараа л болох байх л даа. Хөл гарынхаа тамираар...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хийдээс лам томилоод олон хоногоор эргэх энэ тэр байгаагүй юу?

Норов: Мэдэхгүй байна.

Гантулга: Хошуу нутгийнхаа хилийн дээсээрээ?

Норов: Аа үгүй үгүй мэдэхгүй.Тэрнийг бол би мэдэхгүй. Хүдэр билүү, тэр чинь янз бүрийн юм.Тэнчээ ер нь байдаггүй, шөнөөр шахуу юу яагаад...Уриад л, ширгүүлдээд л лам нар чинь цаг сольчихоод л ...Тэгж л хамгийн сүүлд нь цагаан сарын өмнө л нөгөө хорин есөн гэдэг юм уу.Нөгөө сор зална гээд л .Тэрнийгээ л хийчихээд л тэрний дараа л шинэлдэг байсан.Цогчин сүмийнхээ үүдэн дээр л золгож цуглаж байгаад л...

Гантулга: Шинэлчихнэ?

Норов: Дунд нь нэг ганц лам зогсож байгаад л за бүгдийн амрыг эрье гээд л ...

Гантулга: Цэдэр Лхамаа уншдаг байсан уу?

Норов: Аан?

Гантулга:Цэдэр, битүүний орой нэг Цэдэр Лхам гэж хурдаг ш дээ?

Норов: Ай хурдаг байсан байх.Жагдан ламын цай май гээд бас нэг жигтэйхэн юм болдог байсан, янз бүрийн ...

Гантулга: Хэзээ болдог байсан юм, тэр нь?

Норов:Тэр нь чухам хэзээ болж байсныг нь мэдэхгүй ээ.

Гантулга: Шинийн нэгэнднн юм уу, урьд нь юм уу?

Норов: Аа тэр шинээс тусгай болох байх.Тэр чинь янз бүрийн айл болгон одоо цай хийж авч ирдэг байсан.Чихэртэй, бурамтай, бөөнтэй...

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдрөөр ямар ном хурах вэ?

Норов: Аа тэрийг мэдэхгүй .

Гантулга: Тэрийг бол мээдхгүй юу?

Норов: Юу ч гэсэн нэг ном хурдаг л байсан байх.

Гантулга: Нүгнээ сахидаг байсан уу?

Норов: Сахидаг байсан.

Гантулга: Яаж сахидаг байсан ?

Норов: Нэлээн хойно, хойно нэг нүгнээ сахидаг , нүгнээн жас гэж байдаг байсан.Тэнд очиж нөгөө маань мэгзэмээ уншиж...

Гантулга: Цогчин дацанд чинь өдөр тутмын уншлага гэж байгаа тийм ээ?

Норов: Байдаг л байх.

Гантулга: Тэрийг нь та мэдэхгүй юу?

Норов: Өө мэдэхгүй.Тэр том хурлынхаа завсар зайгаар өдөр тутмын дүйжин хурал гээд...

Гантулга: Дүйжэн?

Норов:Дүйжин. Хүүхдүүд, хүүхдүүд л голцуу.Тэр чинь яг өдөр өнжихгүй, ёстой хурдаг.

Гантулга: Дүйчсэн хурал гэж?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов: Дүйчсэн гэдэг юм уу?

Гантулга: Дүйчсэн.

Норов: Өө би буруу зөрүү ярина л даа.

Гантулга:Цагийн хурал байхгүй юу.

Норов: Цагийн хурал, тогтмол.

Гантулга: Жилдээ ганц болдог юм уу, сард ганц болдог тийм хурлууд байх уу? Дацангийн цогчин дуганы?

Норов: Үгүй ээ ер нь тэгээд дацангууд чинь ер нь жилдээ ганцхан хурдаг юм болов уу даа , мэдэхгүй юм.Манай энд өндөр магсарыг гарахаар л жас гарна.Жишээ нь дуган болгон жастай.Тэр газар нь ус, түлшинд унаа болдог нэг Өндөр лам нэртэй тэнхээтэй ганц лам байсан юм.Хаана л жас гарна тэндээс чинь л юмнуудыг чинь, сундуулыг чинь...

Гантулга: Зөөж авчирдаг?

Норов: Үүрээд л , тэмээгээр авчирна гэж байхгүй.Тэр чинь өөрөө л тэмээ юм. Одоо тэгээд л харж л байад л гэр шиг юм үүрчихсэн л явж л байдаг байсан.

Гантулга: Цогчин дуганыг нь ямар юмаар барьдаг байсан бэ?

Норов: Аан?

Гантулга: Цогчин дуганыг нь модоор барьсан байсан уу, зөнгөөр барьсан байсан уу?

Норов: Зөн зөн, ер нь дандаа л зөн.

Гантулга: Голчилж л зөн барилга байсан уу?

Норов:Дандаа зөн.

Гантулга: Вааран дээвэртэй байсан уу?

Норов: Тийм. Зөн мод тийм байдаг байсан.

Гантулга: Дээвэр нь?

Норов: Тийм, вааран.

Гантулга: Голчилж л тиймэрхүү юмаар барьдаг байсан уу?

Норов: Тийм.

Гантулга: Дөрвөлжин үү, дугуй юу? Хэлбэр дүрс нь , ер нь сүм дуган нь?

Норов: Сүм үү, дөрвөлжин. Дөрвөлжин бөгөөд ер нь буссад дугануудыг бодвол хамаагүй өндөр.

Гантулга: төвд маягийн хийцтэй байсан уу, Хятад маягийн?

Норов: Тийм л байх даа, Төвд л байсан.Хятад яадаг яадаг байсан юм.

Гантулга: Гадна өнгийг нь бол шохойдчих уу, эсвэл зосоор хүрэн болгоод?

Норов: Шохой , дээд талын дээвэр эд нар чинь сааралдуу энэ тэр нь...

Гантулга: Та багшийнхаа талаар нэг тодруулж яриач?

Норов: За би ч, манай нэг ах дүү хоёр багш л байдаг байсан.Одоо байшин нь энд байна.Энэ байшинд, ер нь тэгээд тэр байшингийн ор нь байж л байх юм аа. Гомбо , Лувсан гээд хоёр багш байсан. Лувсан нь ах нь байсан ,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гомбо нь дүү нь байсан.Тэгээд энэ хоёр багш л баригдаад явсан, энэ хоёр багшийн ах дүү нар энэ тэр нь ч гэж байдаггүй.Тэгээд Хэлмэгдлийн үед авна гэсэн хүн байхгүй гэж ийм хоёр багш байдаг байсан.

Гантулга: Энэ ямар цол хэргэмтэй улсууд байсан бэ?

Норов: Багш нар уу?

Гантулга: Тийм, албан тушаал цол хэргэм нь?

Норов: Энэ нэг гэсгүй энэ тэр л хийж явлуу үгүй билүү мэдэхгүй юм аа. Зайсан, дэмчид энэ тэр гээд л цолууд байдаг юм аа. Том том хаамба ламын доорх.Тийм зэргийн л юм байсан болов уу. Тэгээд л тэр манай их багш гээд байгаа чинь цамын дэг мэгийг бол жигтэйхэн сайхан заадаг.Тийм байсан.Цам цохиод л муу сайн хүүхэд багачуул, сүмийн...

Гантулга: Олон шавь нарт заадаг байсан уу?

Норов: Аа заадаг байсан, заадаг байсан.

Гантулга: Энэ цогчин дуганы шавь нар яадаг байсан уу, уншлаганыхаа номыг өдөр бүр шалгалт шүүлэг өгөх үү?

Норов: Өдөр болгоныг нь хэн мэдэхэв.Тэр дацанд, дацанд суучихсан лам нар бол тэр жүн өргөнө ч гэдэг юм уу юу гэдэг юм бэ дээ, шүүлэг өгнө.Тэрнийгээ шүүлгээд л тэгээд тэнцсэн бол дацандаа хурлаа хийнэ, тэнцээгүй бол дахиад сурдаг юм уу, яадаг юм бэ.Тийм л байдаг байсан болов уу?

Гантулга: Та бол дацан мацанд бол байгаагүй , тийм ээ?

Норов: Би бол байгаагүй.Тэр юунд хүрэх цаг бол болоо ч үгүй байсан.

Гантулга: Сангийн далай хийд бол ойр хавийн одоо энэ Балгасны хурал, өөр нэг их олон хурлуудтай бол харилцаж байгаагүй юм уу ?

Норов: Олон хуралтай харилцдаггүй ээ. Эхэн заг.

Гантулга: Энэ хоёртойгоо л ?

Норов: Тийм, Улаан эрэг мэдэхгүй.Наашаа ирж очдог байсан юм уу, үгүй юм уу.

Гантулга: Лам нар нь тэгээд ном хаялцахдаа л ирж?

Норов: Аа тэр ном хаялцдагийг чинь нэлээн сүүл үед л энэ Балгасны лам нараас түршлага авч байж л яаж байгаа юм.Тэр таарамба , дооромбо гэдэг чинь л Чойрын номыг сүрхий мэддэг улсууд байсан байгаа юм. Манай энд бол тийм Чойрын ном, ном хаялцах гэж бол тийм юм байгаагүй.

Гантулга: Энэ дээр ирж улсууд дацан мацанд суудаг байсан уу?

Норов: Өө тэр цогчин уншлагаа дуусгачихаад, тэгээд тэр гадуурх дацангаа хөөцөлддөг байсан байх.Дэс дарааллавал тийм л байна.

Гантулга: Төвд рүү эргэл, мөргөл хийхээр ч юм уу, суралцахаар лам нар явдаг байсан уу ?

Норов: За тэрнийг мэдэхгүй юм.Явдаг байсан байх аа, ер нь бол хойш урагшаа бадарчин гээд лл явдаг байсан гэж байгаа.

Гантулга: Лам нараасаа юу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов: Тийм , хүрээ мэрээ юу явдаг бөх Хайдав гээд нэг бөх хүн байсан юм байна. Тэр одоо хотхүрээ рүү явна гээд л явчихаад л тэнд очиж хурал ном хурчихаад л номын абшиг хүргээд л тэгээд буцахдаа явган хүрээд ирдэг тийм байсан.

Гантулга: Жас олонтой байсан уу?

Норов: Дацан бүр, ер нь сан болгон жастай байсан.

Гантулга: Малын тоо толгой олон байсан уу?

Норов:Тэрнийг бол би мэдэхгүй юм, жас болгон л малтай байсан байх.

Гантулга: Татвар төлдөг байсан уу, хошуу засагдаа?

Норов: Энийг бол мэдэх юм алга.

Гантулга: Лам нар нь хурал дацангаа тойроод амьдардаг байсан уу, байшин саванд?

Норов: Тэгдэг юм байсан байх аа?

Гантулга:Байшин хашаанд?

Норов: Тийм, байшин хашаатай.

Гантулга: Гэрт?

Норов: Тийм, гэрт...

Гантулга: Хурлаа тойроод л ?

Норов: Тийм.Жишээлбэл одоо энэ манайхны байж байгаа чинь лам нарын л байсан...

Гантулга: Зоч лүйжин тавьдаг улсууд байсан уу?

Норов: Аан?

Гантулга: Лам нар дотроосоо ч юмуу, эсвэл өөр хүрээ бараадсан тийм зоч лүйжин гэж улсууд байсан уу, хандмаа нар?

Норов: Зоч хүмүүс бас байдаг байсан.Зоч лүйжин тавина энэ тэр гэж тийм ажил байсан байх.

Гантулга: Жишээлбэл тийм зоч, гээд дуулсан уу?

Норов: За би яг нэрийг нь хэлж мэдэхгүй юм.Чухам гаднаас ирсэн цож байдаг билүү, энэ хийдийн цож байдаг билүү...

Гантулга: Та бол одоо багшийндаа суух уу, гэрт нь суух уу эсвэл тусдаа суух уу?

Норов: Өө тэр цагийн хурал болохоор чинь, хөдөөнөөс л манай эцэг эх аваад ирдэг.Хурал номд суулгах гээд л ийм л байгаа юм.

Гантулга: Та нэг бүтэн өдрийн турш юу хийдэг байснаа ярихгүй юу, өглөө босоод ингэдэг гээд? Сонирхуулж ярихад?

Норов: Одоо яахав дээ, тэр багшийнхаа тогоо шанага, ус түлш юу байдаг юм, ямар үйлчилгээ байдаг юм тэрнээс л хийнэ.Ганц нэг ч шавь ч байхгүй л дээ.

Гантулга: Олон?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Норов: Надаас дээр том өвгөн шавь ч байна, бас идэр залуу шавь нар ч байна.Би ч нэг жаахан жуул банди , шавилсан банди л байсан.

Гантулга: Багш дээр чинь ч юм уу, сүсэгтнүүд их ирдэг байсан уу?

Норов: Аан?

Гантулга:Сүсэгтнүүд?

Норов:Өө ямар хэрэг байхав.За тэр зулын хорин таван гэдэг, баахан зул барьдаг үед чинь хөдөний улсууд цөм ирчихсэн.Голцуул тэр цогчин сүмдээ зул барьж байсан санаад байна.Тэр хойгуур л багшийн үрдүүр л олон зул.Хөдөөнийхэн л цуглачихаад л яаж яаж байдаг юм, тэгж байдаг юм.

Гантулга: хийдийн ойролцоо бол борчуудын хороолол гэж байсан уу?

Норов: Байсан, байдаг байсан.

Гантулга: Юу хийдэг улсууд байсан, тэл нар ер нь хийдэд түлээ авах...?

Норов: Хийд дээр лам нар, бас ядуухан улсууд ирж аяга сахидаг, гурил будаа гээд л гуйлгачин улсууд бас байдаг л байсан.

Гантулга: Зүгээр одоо төрийн хар хүн, сүм хийдийн одоо мужаан ч гэдэг юм уу тийм улсууд байсан уу? Гартай уртай?

Норов: Тийм улсууд ховор л байсан болов уу.Ер нь тэр үед чинь мал нүхдаг хүн ховор байсан.Би явж л , манай багш нэг морь унуулаад л хар хүнд явуулж байсан шиг санаж байдаг юм.Баянхошууны замаар зүүнтээ шогшиж яваад л , Жимээ гэдэг хүнийг Бавуу гэдэг хүнийг хариугүй нурууг нь цохихын алдад... /инээв/ Тэгээд айхтар л малыг нь тасраад авахуулчихсан, голын захад аваачаад л .Тэгээд л тэндээс наашаа ямар түрдэг тэрэг, машин гэж байх юм биш.Үүрээд л өсгөж байсан шиг санагдах юм, дамжлаад л...

Гантулга: Хийдийн ойр орчимд зах зээл байсан уу, худалаа наймаа, Хятадын наймаа?

Норов: Өө хятад л өөд уруугүй явдаг байсан.Тэгээд энэ хийд байж байх үед, нэлээн сүүл үед гааль гээд энэ зүүн дэнж дээр.Одоо юуны гороо гэж байж байсны дэнж. Тэрэн дээр л хятадууд ирчихсэн , майхан шаачихсан.Олон тэмээ ачаа буулгачихсан л байдаг.Гаальлуулж байгаа юм гээд л.Тэгээд л оройхон шиг л нар нэлээн дор орохоор, шингэх шахууд л ачиж аваад л, тэгээд л шөнөжин л алхуулчихдаг байсан байлгүй.

Гантулга: Хурал хэдэн онд хаагдсан бэ, Сангийн далай хийд?

Норов: Одоо аль он юм бэ дээ, намайг цэрэг явахаас хээдн жилийн...хоёр гурван жилийн өмнө л хаагдсан байх.Багцаа нь, миний бодоход бол.Манай багш л нэлээн хойшоо гарч ирсэн юм даа.Тэгээд л цэрэгт явахас өмнө багш нар баригдаад л явж байсан.Тэрний дараахан л цэрэгт явж байсан.

Гантулга: Тэгээд л та хар болсон?

Норов: Тийм.

Гантулга: Тэндээс тийм хүн тушаал өгөөд сүм хийдийг хаалгасан гэж лам нар ярьж байсан уу?

Норов: Үгүй, аймгаас л нэг хар хүн ирж, нэг модон дуган байсан юм.Тэгээд тэнд л бүх лам нарыг цуглуулаад л , тэр албаны хүн.Нэг ногоон дээлтэй л хүн байсан шиг санагддаг юм, нэг савхин шовх гуталтай.Лам нар тэр үед

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

чинь дандаа монгол гуталтай байсан.Нэг тийм хүн хүрч ирээд л тэгээд л хар гутал, ногоон дээлтэй тийм хүн хүрч ирээд л лам нарыг хуралдуулаад л хил хязгаар ч яана яана гэлээ, чухам хил хязгаар...Ингээд л нэг тав хоногийн дотор хойшоо нүү гээд...

Гантулга: Гүрүүгийн хонхор гээд?

Норов: Тийм , Гүрүүгийн хонхор.Тав хоногийн дотор, одоо бодоход тэр Цагаан суварганы ч хаана юм бэ дээ, тэрэн дээр аваач гээд.Тэгэхээр нь лам нар яаж аваачих вэ, чадахгүй гээд.Тэгвэл хураах юм байна гээд л.Тэгээд л маргаашнаас нь тэр хамаг цоожийг нь , сүмийг нь цоожлоод л , лацдаж ломбоддог юм уу, яадаг юм.Тэгээд л лам нарыг нь, байшингаасаа гэрээ ачдаг нь ачаад, байшингаасаа авдаг юмаа аваад тал бүр тийшээ л нүүсэн юмдаг.

Гантулга: Тэр бурхан шүтээн, ном судар нь эндээ тэгээд л цоожтой үлдсэн юм байна ш дээ?

Норов: Өө тэгэлгүй яахав.Цоожтой чигээрээ үлдсэн.Тэгээд энд Очир од гэж, тэр тусгай ч хийсэн юм байдаг юм уу,Очир од гээд л.Наймдугаар отряд л гэдэг юм, тэгээд Очир од гээд цэргийн анги байрлаж авсан. Тэгээд л тэр цэргийн ангийн дарга нар, цэргүүд тэр үед тэр байж байсан цэргүүд энэ хийдийн тэр бурхан, сүмийн юмнууд...

Гантулга: Хэрэглэл?

Норов: Тэр сүмийн хэрэглэл хаа орсныг тэнд л байсан тэр цэргүүд, тэр наймдугаар отрядын байсан үеийн тэр дарга нар цэргүүд л мэднэ.Тэр чинь тараад явчихсан.

Гантулга: Та бол тэгээд л удалгүй цэрэгт явчихсан юм уу?

Норов: Өө тэгэлгүй яахав.

Гантулга: Ерэн онд одоо энэ шашин буцаад дэлгэрэхэд та лам болоогүй юу?

Норов: Үгүй ээ үгүй.

Гантулга: Тэгээд л тэтгэврээ?

Норов:Тэгээд л тэтгэврээ аваад л...

Гантулга: Тэгээд л сууж байгаа?

Норов: Тийм.

Гантулга: Хуучин ер нь лам байсан улсуудтайгаа уулзаж барьсан уу, ер нь социализмын үед уулзаж хааяа энэ тэр хурал номоо хурж, зиндаа цуглаж тэгж байсан уу?

Норов: Хай манай хэд чинь жигтэйхэн хувьсгалч улсууд.Тэгээд л хойшоо энэ бурхан тахил айл гэрийг, мал тууж л мал тууж нэг хоёр жил болов уу даа, засгийн мал.Хойшоо бол тэгээд л айлууд чинь зарим нь сахил махил тавьчихсан, багийн дарга нь хүртэл өөрөө үнзад болчихсон, хүмүүсээ нэг том гэрт цуглуулаад суулгачихсан хурал хурж л байсан. Манай энд бол тийм юм байхгүй.Тэр ч байтугай ерөөсөө сан тавих юм уу, нэг зул барихыг чинь жигтэйхэн цээрлэж байсан.

Гантулга Их хорьдог байж?

Норов:Хамгийн их цээрлэнэ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ таниас өөр энэ хийдийн хуварга үлдсэн байсан хүн байна уу, хажуу айлд чинь нэг хөгшин байж байгаад өнгөрсөн гэж байгаа биз?

Норов: Тийм, тэр хүн байж байгаад өнгөрсөн.

Гантулга: Тэр бол их юм мэдэх хүн байсан биз?

Норов: Аа тэр хүн байсан бол юу, миний мэдэхгүй юмыг ярих байсан байх.Тэгээд тэр хүнээр л шувтарч байх шиг байна.

Гантулга: Одоо тэр өөр улсууд бол таны мэдэх хүн байхгүй юу?

Норов: Байхгүй ээ, одоо энэ аймаг дээр нэг Лувсандаш гээд даралттай өвгөн. Тэр сүүлд бас нэг хэдэн өвгөчүүл, хөгшчүүл нар цуглаж хурал хурж байсан юм.

Гантулга: Хэдэн онд? Ерээд оны эхээр үү?

Норов: Тийм, ерээд оны эхээр, тэр голцуу өвгөчүүл улсууд байсан чинь одоо таалал төгсөөд...

Гантулга: Тэгээд одоо энэ хурал чинь залгаад явж байна уу,эсвэл тасарчихсан?

Норов: Үгүй, тасарчихсан.

Гантулга: Одоо тасарчихсан.

Норов: Тийм.Тэгээд хийдийн лам нь гээд нэг Лувсандаш гээд хүн байсан , одоо тэр аймагт амьд байна уу, үгүй юу.Харвалттай байна уу, үгүй юу.Амйаг дээр.

Гантулга: Дамиран гээд та бас?

Норов: Дамиран гэдэг чинь сайн юм мэддэг ч юм уу, мэддэггүй ч юм уу.Шавилан сууж үзсэн л хүн юм.Осолдохгүй л эндхийн хувилгаан тэр Билэгт хувилгааны ...

Гантулга: Хойд дүр нь?

Норов: Хойд дүр нь гэж л ...

Гантулга: Яригдаж байгаа?

Норов: Яригдсан.

Гантулга: Ширээнд суусан у, тэр хүү?

Норов: Ширээнд суугаагүй байх.

Гантулга: Одоо энэ хийдийг сэргээж байна уу?

Норов: Юу?

Гантулга: Сангийн далай хийдийг сэргээж байна уу?

Норов: Ямар, тэр хүн үү?

Гантулга: Үгүй ээ, одоо энэ улсууд аймаг орон нутгаас?

Норов: Сэргээж байна.Энэ цагаан хүрээ нурсан юм байсан.Энэ цагаан хүрээг л бүтэн болгочихоод, дараа нь одоо хэдэн сүм байна...

Гантулга: Засварыг нь хийж байгаа юу?

Норов: Засварыг нь хийж байгаа байх. Энэ жил одоо будаг голцуу юм хийж байна. Тэгээд энэ чинь одоо...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Гурван зуун жилийн ой хийнэ гэнэ үү?

Норов: Тэгээд энэ чинь хэдэн сүм байна, дөрвөн сүм, таван сүм л алга болчихоод байгаа юм. Таван сүм байхгүй, тэгээд байгаа таван сүмд нь засвар хийгээд, одоо дөхүүлж байна.

Гантулга: Дөхүүлж байна?

Норов: Тэгээд одоо хурдаг лам нарыг нь хаанаасаа олж ирэх юм, одоо мэдэхгүй тэгээд л /инээв/

Гантулга: За сайхан ярилцлага өгсөн таньд баярлалаа.

Норов: Зүгээр ээ, хүү минь мэдэх мэдэхгүй юмаа тэгээд л ярилаа.

Гантулга: За баярлалаа.

Норов: За